

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Д.Эрдэнэбат**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцлээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг улируулан сонгохоор нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг улируулан сонгохоор нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Ц.ДАВААСҮРЭН**



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2014 оны 01 дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Төсвийн байнгын хорооны даргаар сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргаар улируулан сонгосугай.
- 2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ